



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

**Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит тавдугаар хуралдаан
хуралдуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит тавдугаар хуралдааныг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 10⁰⁰ цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуралдааны танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэхээр тогтсугай. Үүнд:

1) Дүүргийн 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай
/Илтгэгч нь: Дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат/

2) Дүүргийн 2018 оны төсөв батлах тухай
/Илтгэгч нь: Дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат/

3) Дүүргийн 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл батлах тухай
/Илтгэгч нь: Дүүргийн Газрын албаны дарга Ж.Мөнх-Эрдэнэ/

4) Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас 2017 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлангийн танилцуулга
/Илтгэгч нь: Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Хурлын Ажлын албаны дарга Ц.Алтанцацрал

2. Хуралдаанд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

3. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/, дүүргийн Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/ нарт даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100149